



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 113

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, удирдамж батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд төрийн өмчийг төлөөлөн оролцох төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага зохицуулалтын хэлтсийн Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга Ц.Шинэхүүг томилсугай.

2. “Монгол шуудан” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд удирдамжийг баримтлан оролцох, хуралд оролцсон тайланг танилцуулахыг төрийн өмчийн төлөөлөгч Ц.Шинэхүүд даалгасугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132081364

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



**“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ТӨРИЙН
ӨМЧИЙГ ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦОХ ТӨЛӨӨЛӨГЧИЙН
БАРИМТЛАХ УДИРДАМЖ**

Төрийн өмчийн төлөөлөгч нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар шийдвэр гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам” болон энэхүү удирдамжийг баримтална:

1.Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлт өгч, гүйцэтгэх удирдлагад үүрэг даалгавар өгөх;

2.Компанийн 2019 оны ногдол ашиг тараасан тухай тайлан болон 2020 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тусган шийдвэрлэх, тогтоолыг танилцуулах.

3.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тусган батлах;

4.Төлөөлөн удирдах зөвлөлийн энгийн болон хараат бус гишүүдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгох;

-----oOo-----